

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН
2018 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/2018.12.11-2019.01.25/

2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр

Чойбалсан хот

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэхийн тулд хийгдэх ажил	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Биелэлт	Хариуцах нэгж, албан хаагч	Хувь
0	1	2	3	4	5	6
Нэг. Албан хаагчдыг давтан сургах чиглэлээр						
1	Шинээр баригдсан албаны байрыг гал түймрээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах үүднээс Бүсийн төв дэх албан хаагчдад сургалт зохион байгуулах	а) Онцгой байдлын газартай хамтран сургалт зохион байгуулах б) Алба хаагч нарыг хамруулах в) Сургалтын дүнг илтгэх хуудсаар танилцуулах	Холбогдох хууль журамд нийцсэн байна.	Тус бүсийн газар нь 2019 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр Дорнод аймгийн Онцгой байдлын газартай хамтарч өдрийн 15 цагаас 17 цаг 30 минутын хооронд 2 цаг 30 минутын сургалтыг бүсийн төвд ажиллаж байгаа төрийн захиргааны 7, төрийн үйлчилгээний 9 нийт 16-н албан хаагчдад зохион байгуулсан. Сургалтыг Онцгой байдлын газрын сургалт хариуцсан ажилтан хошууч Х.Амарсайхан, ахлах дэслэгч Р.Отгонцэцэг нар галын аюулгүй байдал гэж юу болох, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, гал гарсан тохиолдолд ямар арга хэмжээ авах, галын хорын норм стандарт, түүнийг хэрхэн ашиглах, хууль эрх зүйн хүрээнд төрийн байгууллага аж ахуйн нэгж удирдах албан тушаалтнуудын ямар ямар үүрэгтэй, хариуцлагатай байдаг талаарх зөвлөмж, танилцуулга хийсэн. Мөн албаны шинэ байрны бүх өрөө тасалгаануудын гэрэл, цахилгааны холболт, аюулгүй байдлыг шалган зайлшгүй яаралтай авах шаардлагатай нөхцөл байдлын талаар газар дээр нь хэлж зөвлөгөө өгсөн. Сургалт зохион байгуулсан талаараа Зүүн бүс дэх газрын даргад 2019 оны 01 дүгээр сарын 7-ны өдрийн 12/08 дугаар бүхий илтгэх хуудсаар	1. Зүүн бүс дэх газрын дарга Б.Тамир 2. Захиргааны ахлах мэргэжилтэн С.Мөнхжаргал	100

				танилцуулсан.		
2	<p>Бүсийн газрын 2018 оны баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн хэрэг бүрдүүлэх ажиллагааны бэлтгэл ажлын хүрээнд албан хаагчдад хадгаламжийн нэгж хэрхэн бүрдүүлэх талаар арга зүйн сургалт зохион байгуулах</p>	<p>а) Аймгийн архивын тасагтай хамтран сургалтыг зохион байгуулах</p> <p>б) Алба хаагч нарыг хамруулах</p> <p>в) Сургалтын дүнг илтгэх хуудсаар танилцуулах</p>	<p>Хадгаламжийн нэгжийг холбогдох зааврын дагуу бүрдүүлж хэвшсэн байна.</p>	<p>Тус бүсийн газар нь 2019 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр Дорнод аймгийн Архивын Тасагтай хамтарч хамтарч өдрийн 15 цагаас 17 цаг 30 минутын хооронд 2 цаг 30 минутын сургалтыг бүсийн төвд ажиллаж байгаа төрийн захиргааны 7, төрийн үйлчилгээний 9 нийт 16-н албан хаагчдад зохион байгуулсан бөгөөд сургалтыг Дорнод аймгийн архивын Тасгийн сан хөмрөгч Т.Баярмаа заасан. Үүнд: архивийн хадгаламжийн нэгжийг хэрхэн бүрдүүлэх, яаж хэрэг үүсгэх, техник боловсруулалт, эрдэм шинжилгээг ямар дарааллаар ямар стандарт шаардлага хангаж бүрдүүлэх талаар тодорхой зааж өгсөн. Сургалт зохион байгуулсан талаараа Зүүн бүс дэх газрын даргад 2019 оны 01 дүгээр сарын 7-ны өдрийн 12/08 дугаар бүхий илтгэх хуудсаар танилцуулсан.</p> <p>Мөн Байгууллагын даргын 2019 оны 1-01/39 дугаар удирдамжийн дагуу Зүүн бүсэд 01 дүгээр сарын 07-с 16-ны өдрүүдэд ирж ажилласан Захиргаа удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Д.Гантулгаар 1 дүгээр сарын 07-ний өдөр Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/346 дугаар тушаалаар баталсан байгууллагын “Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөх заавар”-ын талаарх 1 цагийн сургалтыг бүсийн төвд ажиллаж байгаа төрийн захиргааны 6, төрийн үйлчилгээний 4 нийт 10-н албан хаагчдын дунд зохион байгуулсан. Сургалтаар тус зааварт туссан онцлох зүйлүүдийг танилцуулахаас гадна байгууллагын архив, сан хөмрөгийн эрхлэгчээс бэлтгэн гаргасан хадгаламжийн нэгж хэрхэн бүрдүүлэх, техник ажиллагааны арга зааврын талаарх 20 минутын видео бичлэгийг үзүүлсэн.</p>	<p>1. Захиргааны ахлах мэргэжилтэн С.Мөнхжаргал</p> <p>2. Сүлжээний инженер Ө.Хосбаяр</p>	100

Хоёр. Хяналт шалгалтын чиглэлээр						
3	Зүүн бүс дэх газрын 2019 оны хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан батлуулах	а) Төлөвлөгөө боловсруулах б) Төлөвлөгөөг Байгууллагын даргаар батлуулах	Хяналт шалгалтын ажиллагаа тодорхой төлөвлөгөөтэй болсон байна.	Хяналт шалгалтын 2018 оны төлөвлөгөөний биелэлтийг гарган дүгнэж, 2019 онд бүсийн хэмжээнд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан, батлуулахаар Төвд хүргүүлсэн.	1. Зүүн бүс дэх газрын дарга Б.Тамир 2. Хяналтын улсын ахлах байцаагч Б.Эрдэнэтуяа	100
Гурав. Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр						
4	БНХАУ-н ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Манжуур хотын Дотоодыг хамгаалах товчоотой байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд Манжуур хотод болох уулзалтад оролцох	а) Уулзалт зохион байгуулах б) Уулзалтын талаар байгууллагын удирдлагад илтгэх хуудсаар танилцуулах	Хамтын ажиллагаа сайжирсан байна.	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотын Дотоодыг хамгаалах товчооны урилгаар БНХАУ-ын Манжуур хотод энэ оны 01 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан урлаг, соёлын арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан уулзалтад Тамгын газрын дарга Д.Давааням, Тамгын газрын тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Гантулга, Зүүн бүс дэх газрын ахлах мэргэжилтэн С.Баясгалан, хяналтын улсын байцаагч Г.Хосбаатар нарын хамт оролцсон. Уулзалтад оролцсон талаараа газрын дарга Б.Тамир байгууллагын даргад 2019 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 01-12/14 дугаар бүхий илтгэх хуудсаар танилцуулсан.		100
Дөрөв. Аюулгүй байдлын чиглэлээр						
	Бүсийн газрын албаны шинэ байрны гадна дотно хэсгийг камержуулах	а) Хяналтын камер худалдан авах судалгаа хийх б) Байгууллагын удирдлагад	Ажлын байрны аюулгүй байдал хангагдсан байна.	Шинэ байрны аюулгүй байдлыг хангах зорилгоор гадаа 4, дотор 8 ширхэг, нийт 12 хяналтын камерын холболтыг бүрэн хийж ажиллагаанд оруулсан. Албаны байрны гадаах орчныг харуулсан 4, зоорийн давхарт 1, 1 давхарын коридорт 2, 2 давхарын коридор,	1.Захиргааны ахлах мэргэжилтэн С.Мөнхжаргал 2. Сүлжээний инженер	100

		<p>танилцуулан шийдвэрлүүлэх в) Бүсийн байрыг иж бүрэн камержуулах ажил хийгдсэн байна</p>		<p>үйлчилгээний танхим, ярилцлагын өрөө, серверын өрөө, хурлын өрөөнд тус тус 1 хяналтын камерыг байрлуулан ажиллагаанд оруулаад байна. Хяналтын камерын төв хадгалах хэсэг мэдээллийн технологийн мэргэжилтний хариуцсан хэсэгт байрлах ба Бүсийн газрын даргын өрөөнд болон жижүүр, харуулын дотор хэсэгт хяналтын дэлгэцийг тус тус холбон байршуулсан. Камер суурьлуулсан ажлын талаараа газрын дарга Б.Тамир байгууллагын даргад 2019 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 01-12/14 дугаар бүхий илтгэх хуудсаар танилцуулсан.</p>	Ө.Хосбаяр	
--	--	---	--	--	-----------	--

ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР